



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/001/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН



Дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор: Т.Хүрэлбаатар

Утас: 70272248 Цахим хаяг: khurelbaatart@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

АДБ. 03. АН № 01/234
танай _____ -ны № _____ -Т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Сумын төсвийн орлогын төлөвлөгөө 16,504,113.1 мянган төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 17,578,120.7 мянган төгрөгийн орлого орж гүйцэтгэл 106,5 хувьтай байна. Татварын 3 шатны орлогын төлөвлөгөө 21,044,105.4 мянган төгрөгөөр батлагдаж гүйцэтгэлээр 23,217,648.1 мянган төгрөг орж гүйцэтгэл 110,3 хувьтай байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 4,234,334.02 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 66 ажлыг хийхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 35 ажлыг гүйцэтгэж 1,792,246.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус сумын 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд 27 хөтөлбөр, 169 арга хэмжээг хэрэгжүүлж 99,2 хувьтай тус тус дүгнэгдсэн байна. Хөтөлбөр арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөсөн төсвийн гүйцэтгэл 74,3 хувь байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

4126020635

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	2025 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	6,591,802.35	8,957,499.73
1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	5,224,691.07	7,541,865.7
1.1.3 АВЛАГА	1,244,034.26	1,219,622.19
1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	123,077.02	196,011.84
1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	28,887,215.69	42,038,317.97
1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	28,887,215.69	42,038,317.97
1.2.2.02 Биет хөрөнгө	28,563,950.42	32,399,299.23
1.2.2.03 Биет бус хөрөнгө	323,265.27	9,639,018.74
1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	35,479,018.03	50,995,817.7
2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	42,975.84	866,148.66
2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	42,975.84	866,148.66
2.1.1.03 Өглөг	42,975.84	866,148.66
2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	35,436,042.19	50,129,669.04
2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	35,436,042.19	50,129,669.04
2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	615,601.65	615,601.65
2.2.1.02 Өмч /төрийн/ /ТӨҮГ/	813,405.35	930,372.35
2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	29,666,111.12	44,242,770.96
2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,340,924.08	4,340,924.08
2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	35,479,018.03	50,995,817.7

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	2025 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	21,228,869.85	30,660,273.84
1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	16,459,131.81	16,492,431.7
1.1.1.03.1 Орлогын албан татвар	12,650,716.25	13,025,918.94
1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	12,650,716.25	13,025,918.94
1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	168,069.6	309,532.79
1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	3,640,345.96	3,156,979.97
1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,179,149.2	14,167,842.14
1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	258,406.71
1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,590,588.84	0.0
1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	16,763,563.02	15,794,828.99
1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	11,646,530.44	14,901,934.88
1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,359,186.04	8,417,952.92
1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,643,981.59	2,126,918.39
1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	258,622.01	259,604.85
1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,850,178.69	3,622,672.37
1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	168,600.95	152,658.41
1.1.2.01.1.05 Нормативт зардал	7,351.26	11,216.24
1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	210,280.54	176,587.89
1.1.2.01.1.07 Томилт, зочны зардал	7,580	5,490
1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	758,768.6	1,360,053.01
1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	2,453,822.4	702,751.75
1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,287,344.41	6,483,981.96
1.1.2.02 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,117,032.58	892,894.11
1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	4,465,306.83	14,865,444.85

1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,519,217.02	302,343.07
1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-3,519,217.02	-302,343.07
1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	946,089.81	14,563,101.78

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ мянган төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	2025 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	20,199,326.49	19,656,259.57
1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	16,459,131.81	16,492,431.7
1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	12,650,716.25	13,025,918.94
1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	168,069.6	309,532.79
1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	3,640,345.96	3,156,979.97
1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,509,927.69	3,022,363.9
1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	125,258.57	134,616.06
1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	5,159.69	0.0
1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,149,605.84	3,163,827.87
1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	2,149,605.84	1,904,260.36
1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	258,406.71
1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	1,001,160.8
1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,590,588.84	0.0
1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,254,248.77	14,620,350.42
1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	10,254,248.77	14,620,350.42
1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,964,019.1	8,135,913.27
1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,002,300.55	2,561,243.27
1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	283,479.86	262,913.47
1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,120,210.96	3,335,364.75
1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	474,474.47	286,920.27
1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	10,567.51	12,976.87
1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	197,887.62	254,746.89
1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	7,580	5,490
1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	433,809.91	870,992.59
1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	433,708.23	545,265.15
1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,290,229.67	6,484,437.16
1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	9,945,077.72	5,035,909.14
1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	7,766,258.93	2,684,357.09
1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,766,258.93	2,684,357.09
1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	7,766,258.93	2,684,357.09
1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-7,766,258.93	-2,684,357.09
1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	196,378.11	691.9
1.1.3.4 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.0	33,685.53
1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-196,378.11	-34,377.43
1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,982,440.68	2,317,174.63
1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,242,250.39	5,224,691.07
1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,224,691.07	7,541,865.7

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	33,636,388.04	33,636,388.04
1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	33,636,388.04	33,636,388.04

1.1.1.1.5 Өмчид гарсан өөрчлөлт	853,564.34	853,564.34
1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	946,089.81	946,089.81
1.1.1.1 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	35,436,042.19	35,436,042.19
1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	35,436,042.19	35,436,042.19
1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	13,558.06	13,558.06
1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	35,449,600.25	35,449,600.25
1.5 Өмчид гарсан өөрчлөлт	116,967	116,967
1.7 Тайлант үеийн үр дүн	14,563,101.78	14,563,101.78
1 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	50,129,669.04	50,129,669.04

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	34,227,391.70	34,687,691.66	(460,299.96)	101.34
11	3.1.01.1.1 Татварын орлого	15,996,613.10	16,492,431.70	(495,818.60)	103.10
110	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	13,032,207.70	13,025,918.94	6,288.76	99.95
1100	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	13,032,207.70	13,025,918.94	6,288.76	99.95
113	3.1.01.1.1.1.3 Хөрөнгийн албан татвар	135,701.50	309,532.79	(173,831.29)	228.10
118	3.1.01.1.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	2,828,703.90	3,156,979.97	(328,276.07)	111.61
1180	3.1.01.1.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,680,300.00	3,022,363.90	(342,063.90)	112.76
1181	3.1.01.1.1.1.8.2 Газрын төлбөр	142,403.90	134,616.06	7,787.84	94.53
1182	3.1.01.1.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	6,000.00	-	6,000.00	-
12	3.1.01.1.2 Татварын бус орлого	18,230,778.60	18,195,259.96	35,518.64	99.81
120	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	719,276.00	1,142,503.90	(423,227.90)	158.84
122	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	16,504,113.10	16,051,595.27	452,517.83	97.26
123	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,007,389.50	1,001,160.80	6,228.70	99.38
II	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	21,967,612.60	16,319,684.69	5,647,927.91	74.29
21	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	14,760,608.70	13,641,542.17	1,119,066.53	92.42
210	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,237,535.20	7,157,105.01	1,080,430.19	86.88
2101	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,014,496.00	1,933,900.03	80,595.97	96.00
2102	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	255,874.20	242,528.59	13,345.61	94.78
2103	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,650,899.20	3,309,827.59	341,071.61	90.66

2104	3.1.01.2.1.1.4	Хангамж, бараа материалын зардал	152,321.50	114,516.26	37,805.24	75.18
2105	3.1.01.2.1.1.5	Нормативт зардал	20,830.00	12,976.87	7,853.13	62.30
2106	3.1.01.2.1.1.6	Эд хогшил, урсгал засварын зардал	322,416.80	254,746.89	67,669.91	79.01
2107	3.1.01.2.1.1.7	Томилолт, зочны зардал	11,320.00	5,490.00	5,830.00	48.50
2108	3.1.01.2.1.1.8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,034,852.80	767,987.31	266,865.49	74.21
2109	3.1.01.2.1.1.9	Бараа үйлчилгээний бусад зардал	774,524.70	515,131.47	259,393.23	66.51
213	3.1.01.2.1.4	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,523,073.50	22,536,032.42	(16,012,958.92)	345.48
2131	3.1.01.2.1.4.1	Засгийн газрын урсгал шилжүүлэг	6,314,039.50	22,365,634.77	(16,051,595.27)	354.22
2132	3.1.01.2.1.4.2	Бусад урсгал шилжүүлэг	209,034.00	170,397.66	38,636.34	81.52
22	3.1.01.2.2	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,995,227.90	2,677,450.62	4,317,777.28	38.28
23	3.1.01.2.3	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	211,776.00	691.90	211,084.10	0.33
230001	3.1.01.2.3.1	Эргэж төлөгдөх зээл	211,776.00	691.90	211,084.10	0.33
4	4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	5,187,888.05		
5	5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	7,523,960.13		
6	6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	160	190	(30.00)	118.75
61	6.1	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	-	100.00
610001	6.1.01	Төсвийн байгууллага	2	2	-	100.00
62	6.2	АЖИЛЛАГСАДЫН ТОО	78	92	(14.00)	117.95
620001	6.2.01	Удирдах ажилтан	11	11	-	100.00
620002	6.2.02	Гүйцэтгэх ажилтан	49	49	-	100.00
620003	6.2.03	Үйлчлэх ажилтан	13	25	(12.00)	192.31
620004	6.2.04	Гэрээт ажилтан	5	7	(2.00)	140.00
65	6.5	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	78	94	(16.00)	120.51
650001	6.5.01	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	22	22	-	100.00
650003	6.5.03	Ажлын албаны албан хаагч (АА)	0	4	(4.00)	
650009	6.5.09	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	20	26	(6.00)	130.00
650010	6.5.10	Гэрээт ажилтан	27	33	(6.00)	122.22
650011	6.5.11	Улс төрийн албан хаагч (УТ)	9	9	-	100.00
66	6.6	НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	2	2	-	100.00
660001	6.6.01	Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	2	2	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	622,352.22	263,167.79
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	622,352.22	263,167.79
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	622,352.22	263,167.79
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	622,352.22	263,167.79
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	622,352.22	263,167.79
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	565,962.74	222,021.88
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	565,962.74	210,354.34
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	463,819.93	210,354.34
2101	1.1.1.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	145,576.37	168,425.46
2102	1.1.1.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,396.51	20,384.88
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	27,797.10	2,064.00
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	5,791.75	-
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	269,258.20	19,480.00
2109	1.1.1.2.1.1.10 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	102,142.80	-
22	1.1.1.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		11,667.54

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй.

Аудитаар илэрсэн зөрчилд 2 зөвлөмж хүргүүлсэн.

Илрүүлсэн зөрчлөөс материаллаг дүн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин болох 124,540.5 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сумын хоршоо хөгжүүлэх сангийн санхүүгийн үйл ажиллагааг албан тушаалын тодорхойлолтын дагуу төсвийн ерөнхий нягтлан бодогч хийж гүйцэтгэхгүй байна. Энэ нь Төрийн албаны зөвлөлийн Төв аймаг дахь салбар зөвлөлийн 2025 оны 208 дугаар тогтоол болон санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сумын хоршоо хөгжүүлэх сангийн санхүүгийн үйл ажиллагааг сумын төсвийн ерөнхий нягтлан бодогчоор гүйцэтгүүлэх.

2. Нийцлийн аудиттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 181 мэдээлэл байршуулахаас 157 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 24 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны цэсэд хуульд заасан мэдээллийг тогтмол шуурхай мэдээлдэг байх.

Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ	1	5,134.7				1	5,134.7			
Дүн	10	74,674.4			1	11,220.0	9	63,454.4		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
ЗДТГ	1	-						1	-
ИТХ	1	-						1	-
Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ	1	-						1	-
Дүн									
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн									
Нийт дүн	3	-						3	-